

АВТО ЗАМЫН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**
Нийтлэг үндэслэл**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь Авто замын сүлжээг төлөвлөх, авто зам, замын байгууламж барих, санхүүжүүлэх, өмчлөх, эзэмших, арчилах, хамгаалах, засварлах, ашиглах, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцаа зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Авто замын тухай хууль тогтоомж

2.1. Авто замын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Авто тээврийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт авто замын сүлжээг төлөвлөх, авто зам, замын байгууламжийг барих, санхүүжүүлэх, өмчлөх, эзэмших, арчилж хамгаалах, засварлах, ашиглах, хяналт тавихтай холбогдох харилцааг зохицуулахад өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүй энэ хууль үйлчилнэ.

4. дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “авто зам” гэж автотээврийн хэрэгсэл зорчиход зориулан барьсан замын байгууламж бүхий хатуу, хайрган хучилттай зам, гудамж, засаж сайжруулсан болон тээврийн хэрэгсэл байнга зорчдог ердийн хөрсөн замыг;

4.1.2. “зорчих хэсэг” гэж авто тээврийн хэрэгсэл зорчиход зориулсан авто зам, замын байгууламжийн хэсгийг;

4.1.3. “зорчих хэсгийн тусгайлсан эгнээ” гэж нийтийн тээврийн хэрэгсэл болон яаралтай тусламж үйлчилгээний тээврийн хэрэгсэл зорчиход зориулсан хэсгийг;

4.1.4. “замын хөвөө” гэж зорчих хэсгийн хоёр хажуугийн зурвас хэсгийг;

4.1.5. “замын байгууламж” гэж бүх төрлийн гүүр, тавилан, гүүрэн гарц, унадаг дугуй болон явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, усны хоолой, ус зайлуулах шуудуу, авто зам, замын байгууламжийн хөдөлгөөнд зориулсан гарц, хонгил, замын хөдөлгөөнийг зохицуулах болон аюулгүй байдлыг хангах зориулалттай авто замын зурвас газарт байгаа авто зогсоол болон бусад байгууламжийг;

4.1.6. “авто замын зурвас газар” гэж авто зам байрлаж байгаа, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, технологийн үйл ажиллагаа явуулах, цаашид замыг өргөтгөхөд зориулсан газрыг;

4.1.7. “хяналт тавих зурвас газар” гэж авто замын зурвас газрын хязгаараас үл хамааран зам хэрэглэгчдийнүзэгдэх орчин, авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажил, ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай газрыг;

4.1.8. “олон улсын чанартай авто зам” гэж Монгол Улсын олон улсын гэрээгээр улс хооронд автотээврийн хэрэгслээр зорчихыг зөвшөөрсөн авто замыг;

4.1.9. “улсын чанартай авто зам” гэж нийслэлийг аймгийн төвтэй, аймгийн төвийг хооронд нь болон хилийн боомттой холбосон авто замыг;

4.1.10. “орон нутгийн чанартай авто зам” гэж аймгийн нутаг дэвсгэр дэхь хот, сум, суурин газар,фермерийн аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн баазыг хооронд нь холбосон болон тэдгээрийн доторх авто замыг;

4.1.11. “нийслэлийн авто зам” гэж Улаанбаатар хот, түүний дагуул хот, дүүргийн нутаг дэвсгэр дэх авто замыг;

4.1.12. “тусгай зориулалтын авто зам” тээвэрлэлтийн онцгой нөхцөл бүхий тусгай зориулалтын тээврийн үйлчилгээнд зориулсан авто замыг;

4.1.13. “аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын авто зам” гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нутаг дэвсгэрт байгаа дотоодын хэрэгцээнд зориулсан авто замыг;

4.1.14. “чанарын баталгаат хугацаа” гэж авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулснаас хойш түүний чанарыг гүйцэтгэгч хариуцаж, гарсан эвдрэл, гэмтлийг өөрийн хөрөнгөөр засварлахаар тогтоосон хугацааг;

4.1.15. “зураг төсөл” гэж авто зам, замын байгууламжийг барих, засварлах, шинэчлэхэд шаардагдах инженер геологийн дүгнэлт, геодезийн хэмжилтийн тайлан, байгаль орчны судалгаа, техникийн болон ажлын зураг, техникийн шаардлага, өртөг зардлын тооцооны нэгдсэн баримт бичгийг;

4.1.16. “зураг төслийн магадлал” гэж авто зам, замын байгууламжийн зураг төслийн хийц, инженерийн шийдэл, тооцоо нь байгаль, цаг уур, газар орны нөхцөлд хэрхэн зохицсон, замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдал нь авто зам, замын байгууламжийн норм, дүрэм, стандартын шаардлагыг хангасан эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг;

4.1.17. “авто замын бүртгэл, мэдээллийн сан” гэж авто зам, замын байгууламжийн үндсэн өгөгдөл, өртөг болон бусад авто зам, замын байгууламжтай холбоотой мэдээллийг агуулсан санг;

4.1.18. “зөвлөх үйлчилгээ” гэж “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 5.1.15-д заасныг;

4.1.19. “замын хөдөлгөөний эрчим” гэж тухайн зам, замын байгууламжаар нэгж хугацаанд зорчиж буй тээврийн хэрэгслийн тоог;

4.1.20. “авто замын арчлалт, урсгал засвар” гэж авто зам, замын байгууламжийн бүрэн бүтэн, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын түвшинг хангах, сайжруулах зорилгоор тогтмол гүйцэтгэх ажлыг.

5 дугаар зүйл. Төрөөс авто замын сүлжээг хөгжүүлэхэд баримтлах зарчим

5.1. Төрөөс авто замын сүлжээг хөгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

5.1.1. улс орны үндэсний аюулгүй байдлыг хангах, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд чиглэсэн үндэсний авто замын сүлжээний хөгжлийн бодлого чиглэл, түүнд үндэслэсэн урт хугацааны төлөвлөгөөтэй байх;

5.1.2. авто замын сүлжээг нэгдсэн арга зүй, стандарт, орчин үеийн дэвшилтэд технологид тулгуурлан хөгжүүлэх;

5.1.3. авто зам барих, арчлан хамгаалах, засварлах, ашиглах үеийн үйл ажиллагаа нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;

5.1.4. авто замын сүлжээг хөгжүүлж, ашиглах удирдлагын нэгдмэл бүтэц, тогтолцоотой байх.

6 дугаар зүйл. Авто замын санхүүжилт

6.1. Авто замын барилга, засвар арчлалтын ажил болон зөвлөх үйлчилгээг улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

6.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дотоод, гадаадын хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчид авто замын салбарын бүтээн байгуулалтад хөрөнгө оруулахыг төрөөс дэмжинэ.

6.3. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хөрөнгө оруулалтаар баригдах авто замын жагсаалтыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

7 дугаар зүйл. Авто замын даатгал

7.1. Авто замыг барих, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, ашиглах, эзэмших үед даатгуулж болно.

7.2. Авто замыг даатгуулах асуудлыг ажлын даалгавар болон ажил гүйцэтгэх гэрээнд тусгах замаар хэрэгжүүлнэ.

8 дугаар зүйл. Авто замын нормативын баримт бичиг

8.1. Авто замын нормативын баримт бичгийн нэгдсэн тогтолцоотой байна.

8.2. Нормативын баримт бичгийг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, холбогдох эрх бүхий байгууллага баталж, мөрдүүлнэ.

8.3. Нормативын баримт бичгийг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүй хувилж, олшруулахыг хориглоно.

8.4. Авто замын нормативыг боловсронгуй болгох, хөгжүүлэх "Нормативын сан"-тай байх бөгөөд уг сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

8.4.1. авто замын барилга, засвар, техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын төсөвт өртгийн 0,18 хувиар тооцсон орлого;

8.4.2. нормативын баримт бичиг борлуулсны орлого;

8.4.3. нормативыг боловсронгуй болгох зорилгоор өгсөн хандив;

8.4.4. бусад.

8.5. Авто замын нормативын сангийн хөрөнгийг нормативын баримт бичиг боловсруулах, судалгаа хийх, шинэчилж боловсронгуй болгох, сурталчлах үйл ажиллагаанд зарцуулна.

8.6. Авто замын нормативыг боловсруулах сангийн үйл ажиллагааны журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Авто замын талаарх төрийн байгууллагын бүрэн эрх

9 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх

9.1. Засгийн газар авто замынталаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. авто замын салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, хяналт тавих;

9.1.2. авто замын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах;

9.1.3. Монгол Улсын үндэсний авто замын сүлжээг хөгжүүлэх бодлого, ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

9.1.4. авто замын салбарын төсөв, төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулж Улсын Их Хурлаар батлуулах;

9.1.5. гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр авто замыг барих, засварлах асуудлыг шийдвэрлэх, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний төслийг хянах, зөвшөөрөл олгох;

9.1.6. авто замын арчлалт, засвар, ашиглалт, эрдэм шинжилгээ судалгааны байгууллага ажиллуулах;

9.1.7. олон улс, улсын чанартай авто замын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор нормативаар тогтоосон авто замын арчлалт урсгал засварт шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган батлуулах, хэрэгжилтийг хангуулах.

10 дугаар зүйл. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

10.1. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1. авто замын тухай хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах;

10.1.2. авто замын салбарт шинжлэх ухааны ололт, шинэ техник технологи нэвтрүүлэх болон хүний нөөцийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

10.1.3. авто замын салбарын мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн зэрэг олгох журмыг батлан хэрэгжүүлэх;

10.1.4. олон улс, улсын чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг нийгэм, эдийн засгийн ач холбогдол, үр өгөөжөөр нь эрэмбэлэн боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

10.1.5. үндэсний авто замын сүлжээн дэх олон улс, улсын чанартай, тусгай зориулалтын авто замын чиглэл, урт, дугаарыг тогтоож батлах;

10.1.6. судалгаа шинжилгээний үндсэн дээр замын хийц технологи, материалын чанарт мэргэжлийн дүгнэлт гаргах, норматив, үнэ бүрдэлтийг боловсронгуй болгох, шинэ техник технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

10.1.7. олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын барилга, засвар, арчлалтын ажил энэ хүрээнд хийгдэх зөвлөх үйлчилгээг улсын төсөв, гадаадын зээл, тусламж бусад эх үүсвэрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

10.1.8. авто зам барих, арчлах, засварлах, хамгаалах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон нормативын баримт бичиг, дүрэм, журмыг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

10.1.9. тусгай зориулалтын авто зам барих, арчлах, засварлах, ашиглахтай холбогдсон журам баталж, мөрдүүлэх;

10.1.10. нийслэл, хот, орон нутгийн чанартай авто замыг хөгжүүлэх бодлого, ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд нийслэл, хот, аймгийн Засаг дарга нарыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, биелэлтэд хяналт тавих;

10.1.11. олон улс, улсын чанартай, тусгай зориулалтын авто замынашиглалт, арчлалт, засварын ажлыг нэгдсэн бодлого, мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангаж, замын хөдөлгөөний аюулгүй, ашиглалтын бэлэн байдлыг хангуулах;

10.1.12. олон улс, улсын чанартай, тусгай зориулалтын авто замын ашиглалтад авах, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэн өмчийн бүртгэлд оруулах, элэгдэл хорогдлыг тооцох, авто зам, замын байгууламжийг зохих журмын дагуу бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах;

10.1.13. олон улс, улс, нийслэл, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто замын бүрэн бүтэн байдал, ашиглалтын хэвийн нөхцлийг хангах талаар улсын хэмжээнд хуулийн этгээдэд үүрэг, чиглэл өгч, биелэлтийг хангуулах;

10.1.14. авто замыг барих, засварлах, замын барилгын материал үйлдвэрлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлийн журмыг батлах, тусгай зөвшөөрөл олгох.

11 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

11.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга авто замын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1. авто замын үндэсний сүлжээг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулан тухайн нийслэл, орон нутгийн авто замын сүлжээг хөгжүүлэх бодлого, ерөнхий төлөвлөгөөг боловсруулж авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах, биелэлтийг зохион байгуулах;

11.1.2. авто замын тухай хууль тогтоомж, Засгийн газрын болон авто, замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх;

11.1.3. нийслэл, орон нутгийн чанартай авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах ажлыг зохион байгуулах;

11.1.4. нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдах авто замын барилга, засвар, арчлалтын ажлыг зохион байгуулах;

11.1.5. олон улс, улсын болон орон нутгийн чанартай тусгай зориулалтын авто замын бүрэн бүтэн байдал, хамгаалалтын талаар нутаг дэвсгэрийнхээ байгууллага, иргэнд үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах;

11.1.6. нийслэлийн авто замыг санхүүжүүлэх, барих, засаж арчлах, ашиглах талаарх журам боловсруулан авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулах, хэрэгжүүлэх;

11.1.7. байгалийн гамшиг, гэнэтийн осол, аюулын улмаас авто замд эвдрэл, гэмтэл гарч шуурхай засварлах шаардлага гарсан үед нутаг дэвсгэртээ байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс тээвэр, холбооны хэрэгсэл, машин механизм, эд хөрөнгийг нөхөн олговортойгоор гаргуулах, хүн хүчний туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

11.1.8. тухайн нутаг дэвсгэртээ авто замын хөдөлгөөнийг зохих хууль, журмын дагуу зохион байгуулах;

11.1.9. аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахдаа авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авах.

12 дугаар зүйл. Төрийн бус байгууллагын оролцоо

12.1. Авто замын салбарын төрийн бус байгууллагууд нь авто замын тухай хууль тогтоомж, норм, дүрэм, стандарт, эрх зүйн бусад баримт бичгийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх, төрөөс үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулна.

12.2. Төрийн бус байгууллага энэ хуулийн 12.1-д заасан ажлыг гэрээгээр гүйцэтгэж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Авто замын сүлжээ, авто замын ангилал, бүрэлдэхүүн, өмчлөгч, эзэмшигч

13 дугаар зүйл. Авто замын сүлжээ

13.1. Монгол Улсын үндэсний авто замын сүлжээ нь олон улс, улс, нийслэл, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто замаас бүрдэнэ.

13.2. Олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.

13.3. Нийслэл, орон нутгийн чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг олон улс, улсын чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал батална.

13.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 13.3-д заасан төлөвлөгөөг боловсруулж батлуулахдаа авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авсан байна.

14 дүгээр зүйл. Авто замын ангилал

14.1. Авто замыг зориулалтаар нь дор дурдсанаар ангилна:

14.1.1. олон улсын чанартай авто зам;

14.1.2. улсын чанартай авто зам;

14.1.3. орон нутгийн чанартай авто зам;

14.1.4. нийслэлийн авто зам;

14.1.5. тусгай зориулалтын авто зам;

14.1.6. аж ахуйн нэгж байгууллагын дотоодын авто зам.

14.2. Авто замыг тодорхой ангилалд хамааруулах, нэг ангиллаас нөгөө ангилалд шилжүүлэх асуудлыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

14.3. Авто зам нь чиглэлийн нэр, дугаартай байна. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын чиглэлийн нэр, дугаарыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын чиглэлийн нэр, дугаарыг тухайн шатны Засаг дарга, авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн тогтооно.

14.4. Авто замын төсөллөлтийн үндсэн шаардлага, хөдөлгөөний үйлчилгээний түвшин, техникийн үзүүлэлтээр нь ангилж зэрэглэл тогтооно. Авто замын ангилал, зэрэглэл тогтоох, түүнд тавигдах шаардлагыг нормативын баримт бичгээр зохицуулна.

15 угаар зүйл. Авто замын бүрэлдэхүүн

15.1. Авто зам нь дараах хэсгээс бүрдэнэ:

15.1.1. зорчих хэсэг;

15.1.2. замын хөвөө;

15.1.3. замын байгууламж;

15.1.4. авто замын зурвас газар;

15.1.5. хяналт тавих зурвас газар.

15.2. Олон улс, улсын чанартай авто замын зурвас газрын өргөн 100 м /авто замын тэнхлэгээс 2 талд тус бүр 50 м/, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто замын зурвас газрын өргөн 60 м /авто замын тэнхлэгээс 2 талд тус бүр 30 м/, нийслэл, хотын замын зурвас газрын өргөнийг хотын авто замын ангилал, хот, тосгоны төлөвлөлт, холбогдох норм, дүрэмд зааснаар тогтооно.

15.3. Онцгой тохиолдолд тухайн авто замын болон газар нутгийн онцлогтой уялдуулан олон улс, улсын чанартай авто замын зурвас газрын өргөнийг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай

авто замын зурвас газрын өргөнийг аймаг, нийслэлийн Засаг дарга зураг төсөл, холбогдох норм, дүрмийн хүрээнд тогтоож болно.

15.4. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалттай авто замын хяналт тавих зурвас газрын өргөнийг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын хяналт тавих зурвас газрын өргөнийг зураг төслийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус тогтооно.

15.5. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын зурвас газарт газар өмчлүүлэхийг хориглох бөгөөд түр эзэмшүүлэх асуудлыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

16 дугаар зүйл. Авто замын өмчлөгч

16.1. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын өмчлөгч нь төр байна.

16.2. Орон нутгийн чанартай болон нийслэлийн авто замын өмчлөгч нь аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал байна.

16.3. Тусгай зориулалтын авто замын хөрөнгө оруулагч нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр өмчлөгч байж болно.

16.4. Аж ахуйн нэгж байгууллагын дотоодын авто замын өмчлөгч нь тухайн аж ахуйн нэгж байгууллага байна.

16.5. Хуулийн этгээд нь концессын гэрээгээр энэ хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу авто замыг барьж, өмчилж болно.

17 дугаар зүйл. Авто замын эзэмшигч

17.1. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, түүний зурвас газрын эзэмшигч нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүнээс эрх олгосон этгээд байна.

17.2. Нийслэл, орон нутгийн чанартай авто зам, түүний зурвас газрын эзэмшигч нь аймаг, нийслэлийн Засаг дарга түүнээс эрх олгосон этгээд байна.

17.3. Энэ хуулийн 16.3, 16.4, 16.5-д заасан тохиолдолд авто замын эзэмшигч нь тухайн авто замын өмчлөгч түүнээс эрх олгосон этгээд байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ Авто зам барих

18 дугаар зүйл. Авто замын техник эдийн засгийн үндэслэл

18.1. Авто замын захиалагч нь техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ боловсруулж, тухайн авто замын үр өгөөжийг тодорхойлж болно.

18.2. Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаврыг олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын замд авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замд аймаг, нийслэлийн Засаг дарга, бусад авто замд тухайн замын захиалагч батална.

19 дүгээр зүйл. Авто замын зураг төсөл

19.1. Авто замын зураг төслийг захиалагчийн баталсан зургийн даалгаврын дагуу тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

19.2. Авто замын зураг төсөлд тавигдах шаардлага:

19.2.1. зураг төсөл зохиох зургийн даалгавар, геодезийн хэмжилт, инженер геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөл, нормативын баримт бичгийн дагуу боловсруулагдсан байх;

19.2.2. эрүүл ахуй, хөдөлгөөний аюулгүй байдал, байгаль орчин, түүх, соёлын дурсгалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөл боломжийг хангасан байх;

19.2.3. тухайн авто замын барилга, засварын ажилд хэрэглэх материалд тавигдах шаардлага, технологийн үе шатны үйл ажиллагааг нарийвчлан тусгасан техникийн шаардлагыг боловсруулсан байх;

19.2.4. авто замын зураг төсөлд эрх бүхий этгээдээр магадлал хийлгэж, экспертизийн дүгнэлт гаргуулж, баталгаажуулсан байх.

19.3. Авто замын зураг төсөлд магадлал хийж, экспертизийн дүгнэлт гаргах журмыг Авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.4. Зураг төслийн алдааг зураг төслийг боловсруулсан байгууллага, зохиогч хариуцах бөгөөд магадлал хийсэн этгээд нь зураг төслийн техникийн шийдлийн талаар гаргасан дүгнэлтдээ хариуцлага хүлээнэ.

20 дугаар зүйл. Авто замын барилгын ажил

20.1. Авто зам, замын байгууламжийг барих ажлыг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд холбогдох хууль, журмын дагуу захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

20.2. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын гүйцэтгэгч нь холбогдох хууль тогтоомж, нормативын баримт бичиг, техник технологи, эрүүл ахуй, байгаль орчны болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

20.3. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг зураг төсөлгүй, техник технологийн хяналтгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

20.4. Тусгай зориулалтын авто зам барих, ашиглах журмыг Засгийн газар батална.

20.5. Авто замын барилгын ажил нь төмөр зам, харилцаа холбооны болон цахилгааны шугам, цэвэр бохир усны хоолой, барилга байгууламжийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөр бол холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцөж зөвшөөрөл авсан байна.

20.6. Захиалагч байгууллага нь авто замын барилгын ажлыг эхлүүлэх, саадгүй хэрэгжүүлэхэд шаардагдах зураг төсөл, замын чиг /трасс/, геодезийн цэгүүд, газар эзэмшүүлэх зөвшөөрөл зэргийг гүйцэтгэгчид хүлээлгэн өгч талбай чөлөөлөх асуудлыг шийдвэрлэсэн байна.

20.7. Шинээр авто зам, замын байгууламжийг барих зорилгоор газар, түүний хэвлийг хөндөхөөс өмнө палентлоги, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулах, илэрсэн дурсгалыг авран хамгаалах үүрэгтэй.

20.8. Авто замын барилгын ажлыг саадгүй, хэвийн явагдахад аймаг, нийслэл, орон нутгийн төр захиргааны болон аж ахуйн байгууллага дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

21 дүгээр зүйл. Авто замын барилгын ажлын технологийн хяналт

21.1. Авто замын барилгын ажлын технологийн хяналтыг тусгай зөвшөөрөл бүхий, мэргэжлийн эрх бүхий этгээд захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр хэрэгжүүлнэ.

21.2. Авто замын барилгын ажлын технологийн хяналтыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21.3. Технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардлыг тухайн авто замын төсөвт өртөгт тусгана.

ТАВДУГААР БҮЛЭГ Авто замын арчлалт, засвар

22 дугаар зүйл. Авто замын арчлалт, засварын ажил

22.1. Авто замын арчлалт, засварын ажлыг тухайн замыг эзэмшигч байгууллага хариуцан зохион байгуулна.

22.2. Авто замын арчлалт, засварын ажлыг дараах байдлаар ангилна:

22.2.1. арчлалт;

22.2.2. урсгал засвар;

22.2.3. ээлжит засвар;

22.2.4. их засвар, шинэчлэлт;

22.2.5. гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засвар.

22.3. Авто замын арчлалт, засварын ажлын ангилалд тавигдах шаардлагыг нормативын баримт бичгээр тогтооно.

22.4. Авто замын арчлалт, урсгал, ээлжит засвар, гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлыг тухайн замыг хариуцагч байгууллага гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд ээлжит болон гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр гэрээгээр гүйцэтгүүлж болно.

22.5. Авто замын их засвар, шинэчлэлтийн ажлыг замын барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

22.6. Авто замын их засвар, шинэчлэлтийн ажлын технологийн хяналтыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

22.7. Авто замын арчлалт, урсгал засварын ажлыг тухайн авто замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлнэ.

22.8. Замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлэх норм болон хэрэгжүүлэх журмыг Засгийн газар батална.

23 дугаар зүйл. Авто замын арчлалт, урсгал засвар хамгаалалт хариуцагч байгууллага

23.1. Авто замын ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг байнга хангаж арчлалт, урсгал засварын ажлыг тогтмол гүйцэтгэх чиг үүрэг бүхий зам хариуцагч байгууллага байна.

23.2. Зам хариуцагч байгууллагын хариуцах замын чиглэл, уртыг тухайн авто замын эзэмшигч байгууллага тогтооно.

23.3. Зам хариуцагч байгууллага нь дараах үүргийг хэрэгжүүлнэ.

23.3.1. авто замын ашиглалтын байнгын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангах;

23.3.2. авто замд тогтоосон журмын дагуу үзлэг хийж арчлалт, засварыг тогтмол хийх;

23.3.3. хариуцсан авто замынхаа бүртгэл хөтөлж, мэдээллийн сан байгуулан зам хэрэглэгчдэд мэдээлж байх;

23.3.4. авто замын зурвас болон хяналт тавих зурвас газрыг хамгаалах;

23.3.5. авто замын ашиглалтын талаар зам өмчлөгч болон эзэмшигчид тогтмол мэдээлж байх;

23.3.6. гамшиг ослын улмаас авто замд эвдрэл, гэмтэл гарч тээврийн хэрэгслийн хөдөлгөөн саатсан үед нийтэд шуурхай мэдээлж саатлыг арилгах арга хэмжээг яаралтай авах;

23.3.7. авто замаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү овор, даацтай буюу тусгай хамгаалалтгүйгээр гинжит дугуйтай тээврийн хэрэгсэл зорчихоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хяналт тавих;

23.3.8. тухайн нутаг дэвсгэрт авто замын хөдөлгөөний эрчмийн тооллогыг зохих журмын дагуу зохион байгуулах;

23.4. Авто замын арчлалт, урсгал засварын ажил гүйцэтгэх зам хариуцагч байгууллагыг сонгон шалгаруулалтаар сонгож гэрээний үндсэн дээр ажиллуулж болно.

24 дүгээр зүйл. Авто замын сан

24.1. Олон улс, улс, нийслэл болон орон нутгийн чанартай авто замын арчлалт, засвар болон түүнтэй холбогдох үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалт бүхий "Авто замын сан"-тай байна.

24.2. Авто замын санг улс, нийслэл, орон нутгийн гэж ангилна.

24.3. Улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ.

24.4. Авто замын сангийн хөрөнгөөр авто замын арчлалт, урсгал засвар, гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлыг тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ.

24.5. Авто, замын засвар арчлалт хариуцсан байгууллагын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, техник технологийг шинэчлэх, мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх, авто замын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавихад шаардагдах зардлыг авто замын сангаас санхүүжүүлнэ.

24.6. Улсын авто замын сан нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын, нийслэл, орон нутгийн авто замын сан нь аймаг, нийслэлийн Засаг даргын мэдэлд байна.

24.7. Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журмыг Засгийн газар батална.

24.8. Авто замын сангийн хөрөнгийг энэ хуулийн 24.3, 24.4, 24.5-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

24.9. Тухайн жилд улсын чанартай авто замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажил, зарцуулах хөрөнгийн төлөвлөгөөг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажил, зарцуулах хөрөнгийн төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус баталж хэрэгжүүлнэ.

25 дугаар зүйл. Авто замын сангийн хөрөнгийн эх үүсвэр

25.1. Улсын чанартай авто замын сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

25.1.1. авто бензин, дизелийн түлшний албан татвар;

25.1.2. импортоор оруулж байгаа автомашины онцгой албан татвар;

25.1.3. гадаадын зээл, тусламж, хандивын хөрөнгө;

25.1.4. улсын төсвийн хөрөнгө;

25.1.5. олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам ашигласны төлбөр;

25.1.6. олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын болон энэ хуулийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль;

25.1.7. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын тээврийн хэрэгслээс авах төлбөр, хураамж;

25.1.8. авто замын зурвас газарт холбогдох зөвшөөрлийн дагуу үйлчилгээ эрхэлсний төлбөр;

25.1.9. бусад.

25.2. Нийслэл, орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

25.2.1. авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар;

25.2.2. нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө;

25.2.3. гадаадын зээл, тусламж хандивын хөрөнгө;

25.2.4. агаарын бохирдлын хураамж;

25.2.5. нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын болон энэ хуулийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль;

25.2.6. нийслэл болон орон нутгийн авто зам, зогсоол ашигласны төлбөр;

25.2.7. авто замын зурвас газарт холбогдох зөвшөөрлийн дагуу үйлчилгээ эрхэлсний төлбөр;

25.2.8. бусад.

26 дугаар зүйл. Авто замын зөвлөл

26.1. Авто замын бэлэн байдлын түвшин, аюулгүй байдлыг хангах болон авто замын сангийн хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалтад тавих олон нийтийн хяналтыг зам хэрэглэгчдийн төлөөллөөс бүрдсэн авто замын зөвлөл хэрэгжүүлнэ.

26.2. Авто замын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.

26.3. Авто замын бэлэн байдлын түвшин, аюулгүй байдлыг хангах, авто замын сангийн үйл ажиллагааны талаар Авто замын зөвлөлөөс гаргасан дүгнэлт, зөвлөмжийг авто зам өмчлөгч, эзэмшигч, хариуцагч байгууллага биелүүлэх үүрэгтэй.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ Авто замын бүртгэл, мэдээлэл

27 дугаар зүйл. Авто замын бүртгэл, мэдээллийн сан

27.1. Авто замын бүртгэл, мэдээллийн сан нь авто зам, замын байгууламжтай холбоотой дараах мэдээллээс бүрдэнэ:

27.1.1. техникийн болон ашиглалтын үзүүлэлтүүд;

27.1.2. хүчин чадал, зэрэглэл, төлөв байдал;

27.1.3. төсөвт өртөг, элэгдэл, хорогдлын бүртгэл, мэдээлэл;

27.1.4. ашиглалтад орсон хугацаа;

27.1.5. авто зам, замын байгууламжид хийсэн засварын мэдээлэл;

27.1.6. тухайн авто зам, замын байгууламжид гарсан эвдрэл, зам тээврийн ослын мэдээ;

27.1.7. бусад.

27.2. Олон улс, улс болон тусгай зориулалтын авто замын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг аймаг, нийслэлийн Засаг дарга эрхэлэн хөтөлнө.

27.3. Зам хариуцагч байгууллага тухайн хариуцсан зам, замын байгууламжийн бүртгэл мэдээллийн санг хөтөлж жил тутам тогтоосон хугацаанд авто зам эзэмшигч байгууллагад хүргүүлнэ.

27.4. Олон улс, улсын болон тусгай зохиулалтын авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмыг авто замын асуудал эрхлэсэн Засгийн газрын гишүүн, нийслэл, орон нутгийн чанартай авто замын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга баталж мөрдүүлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

Авто зам, замын байгууламжийг ашиглах

28 дугаар зүйл. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах

28.1. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замыг ашиглалтад авах асуудлыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замыг ашиглалтад авах асуудлыг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.

28.2. Энэ хуулийн 28.1-д зааснаас бусад авто замыг ашиглалтад авах асуудлыг захиалагч байгууллага хариуцна.

28.3. Авто замыг ашиглалтад авах журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

28.4. Авто замын чанарын баталгаат хугацаа нь замын ангилал, гүйцэтгэсэн ажлын төрлөөс хамааруулан 1-2 жил байх бөгөөд баталгаат хугацааны үйл ажиллагааг гэрээгээр зохицуулна.

29 дүгээр зүйл. Авто зам ашиглах

29.1. Иргэн, хуулийн этгээд нь тэдгээрийн харьяалал, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр авто замыг ашиглах эрхтэй.

29.2. Авто зам ашиглагч нь дараахэрх, үүрэгтэй:

29.2.1. хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд авто зам, замын байгууламжийг үнэ төлбөргүй ашиглах;

29.2.2. энэ хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийг биелүүлэх;

29.2.3. авто замын арчлалт, засвар, хөдөлгөөний аюулгүй байдлын талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах, шаардлага тавих;

29.2.4. авто замын засвар, арчлалт, хамгаалалт хариуцсан байгууллагын буруугаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;

29.2.5. авто замд бий болсон, ноцтой хохирол учруулж болзошгүй эвдрэл, зөрчлийн талаар хариуцсан байгууллагад нэн даруй мэдээлэх;

29.2.6. барилга байгууламж барих, өргөтгөх, шугам сүлжээнд холболт хийх зэрэг зайлшгүй шаардлагаар авто зам сэтлэх, орц гарц гаргах бол авто зам эзэмшигч байгууллагаас албан ёсны зөвшөөрөл авч гүйцэтгэн ашиглалтын хэвийн нөхцөлд нь буцаан оруулж, хүлээлгэн өгөх.

29.3. Авто зам хэрэглэгч дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

29.3.1. авто замыг эвдэж гэмтээх;

29.3.2. зохих зөвшөөрөлгүйгээр авто замын бүтэц, төлөвлөлт, зориулалтад өөрчлөлт оруулах;

29.3.3. авто зам барих, засварлах, арчилж хамгаалах ажилд саад учруулах;

29.3.4. авто замын зорчих хэсэг, хөвөө, зурвас газарт хог хаях, ус урсгах, чулуу, төмөр зэрэг зүйлс үлдээх, хөдөлгөөнд саад учруулж, үзэгдэх орчин хязгаарласан хаяг сурталчилгааны самбар, эд зүйлс байрлуулах;

29.3.5. тусгай хамгаалалтгүй, эсвэл зөвшөөрөлгүйгээр гинжит болон тухайн авто замын үзүүлэлтээс хэтэрсэн овор, хэмжээ, даацтай тээврийн хэрэгсэл зорчуулах;

29.3.6. авто замын зурвас газарт авто замын ашиглалттай холбоогүй болон эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй худалдаа, үйлчилгээ эрхлэх;

29.3.7. хууль тогтоомжоор хориглосон бусад үйл ажиллагаа.

30 дугаар зүйл. Авто зам ашигласны төлбөр

30.1. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замаас төлбөр авах замын чиглэл, урт, төлбөрийн хэмжээг Засгийн газар, нийслэл, орон нутгийн чанартай болон аж ахуйн нэгж байгууллагын дотоодын авто замаас төлбөр авах замын чиглэл, урт, төлбөрийн хэмжээг тухайн аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал тус тус тогтооно.

30.2. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замаас төлбөр авах үйл ажиллагааны журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30.3. Нийслэл, орон нутгийн чанартай болон аж ахуйн нэгж байгууллагын дотоодын авто замаас төлбөр авах үйл ажиллагааны журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга баталж, мөрдүүлнэ.

30.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тээврийн хэрэгслийг авто зам ашигласны төлбөрөөс чөлөөлнө.

31 дүгээр зүйл. Авто замыг хаах

31.1. Авто замд болон авто тээврийн хөдөлгөөнд аюул учирч болох нөхцөл байдал бий болж тээврийн хэрэгсэл зорчих боломжгүй болсон, авто замд засвар хийх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд авто замыг хааж болно.

31.2. Авто замыг хаах, замын чиглэл өөрчлөх журмыг Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, мөрдүүлнэ.

32 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

32.1. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замыг ашиглахтай холбогдон үүссэн маргааныг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

32.2. Нийслэл, орон нутгийн чанартай болон аж ахуйн нэгж байгууллагын авто замыг ашиглахтай холбогдон үүссэн маргааныг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэнэ.

32.3. Энэ хуулийн 31.1, 31.2-т заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр маргааныг шийдвэрлэгдэж чадаагүй гэж үзвэл шүүхэд хандаж болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ
Авто зам барих, засварлах, арчлах, зөвлөх үйлчилгээ
үзүүлэхтусгай зөвшөөрөл

33 дугаар зүйл. Авто зам барих, засварлах, арчлах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл

33.1. Авто замын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуульд заасан нөхцөл шаардлагын дагуу олгоно.

33.2. Авто замын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэгчид тавигдах шаардлагыг нарийвчлан тусгасан журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж мөрдүүлнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ Авто замд тавих улсын хяналт

34 дүгээр зүйл. Авто замын улсын хяналт

34.1. Авто замыг барих, арчлах, засварлах, хамгаалах, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтэд тавих улсын /төрийн/ хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага, бүх шатны засаг дарга, авто замын бусад өмчлөгч, эзэмшигч, зам хариуцагч байгууллага, албан тушаалтан эрх хэмжээнийхээ дагуу хэрэгжүүлнэ. \

34.2. Авто замын улсын /төрийн/ хяналтыг “Төрийн хяналт, шалгалтын тухай” хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ Бусад зүйл

35 дугаар зүйл. Авто замын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

35.1. Авто замын тухай хууль, тогтоомж зөрчсөний улмаас бусдад учруулсан хохирлыг хууль тогтоомжид заасны дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

35.2. Авто замын ашиглалтын хэвийн нөхцөл хангагдаагүйгээс иргэн хуулийн этгээдэд хохирол учирсан болохыг хууль, хяналтын байгууллага тогтоосон бол тухайн авто зам хариуцагч болон эзэмшигч байгууллага уг хохирлыг хариуцан төлнө.

35.3. Авто замын тухай хууль, тогтоомж зөрчсөн этгээд гарсан хохирлыг нөхөн төлсөн нь түүнийг хуулийн бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

35.4. Авто замын тухай хууль, тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчлийн шинж байдлыг харгалзан Замын, хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 54-р зүйлийн холбогдох заалтын дагуу шийтгэлийг эрх бүхий албан тушаалтан ногдуулна.

35.5. Энэ хуулийн 29.2.6, 37.3.1, 27.3.2, 27.3.5, 27.3.7-д заасныг зөрчсөн иргэн, албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-2 дахин нэмэгдүүлсэн, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгөөр торгох шийтгэл ногдуулж, учруулсан хохирлыг бүрэн барагдуулна.

35.6. Энэ хуулийн 29.3.3, 29.3.4, 29.3.6-д заасныг зөрчсөн иргэн, албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-5

дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4-8 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгөөр торгох шийтгэл ногдуулж, зөрчлийг арилгуулна.

35.7. Энэ хуулийн 20.2, 20.3, 20.9, 26.3–д заасныг зөрчсөн иргэн, албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-5 дахин нэмэгдүүлсэн, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгөөр торгох шийтгэл ногдуулж, зөрчлийг арилгуулна.

35.8. Тусгай зөвшөөрөлгүйгээр авто зам барих, арчлах, засварлах, зураг төсөл боловсруулах, техник технологийн хяналт хийх ажил эрхэлсэн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийг зөрчлийн шинж байдлыг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгөөр торгож, зөрчлийг арилгуулна.

36 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

36.1. Энэ хуулийг 2015 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Барилгын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “зам гүүр” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙН ХУУЛЬ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дах заалтын ... ариутгах татуурга, зам гэсний дараа “замын зурвас газар” гэж нэмж оруулсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.15.4 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай;

“15.15.4. авто замын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, авто зам, замын байгууламж барих, засварлах, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Авто замын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АВТОБЕНЗИН, ДИЗЕЛИЙН ТҮЛШНИЙ АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.Гаалийн байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн төлсөн автобензин, дизелийн түлшний албан татварыг уг албан татвар дансанд орсноос хойш ажлын 5 хоногт багтаан улсын авто замын санд төвлөрүүлнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Авто замын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ